

ФИНТЕК БА РЕГТЕК

КРАУДФАНДИНГ


Платформоор дамжуулан бага хэмжээний мөнгийг олон санхүүжүүлэгчдээс татаж аливаа төсөл, бизнесийг санхүүжүүлэх, түүнийг зуучлах үйл ажиллагааг краудфандинг буюу олон нийтийн санхүүжилт гэнэ.

Зураг . Олон нийтийн санхүүжилтийн хялбарчилсан схем



Судлаачид краудфандингийн хөгжлийн хурдацтай өсөлтийг WEB 2.0-ийн технологийн шинэчлэл болон 2007–2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас үүдэлтэй гэж үздэг. Санхүүгийн хямралын үед АНУ-ын Lehman Brothers банк дампуурсны дараа Европ, Хойд Америкт банкны зээл олголт зогсонги байдалд орсон. Үүнээс шалтгаалан жижиг, дунд бизнес эрхлэгчид (ЖДҮ) болон хувь хүмүүсийн санхүүжилт мэдэгдэхүйц буурч, улмаар мөнгө босгох өөр арга болох олон нийтийн санхүүжилтийн шинэ загварууд бий болж эхэлсэн (Darr 2013; Hagedorn and Pinkwart 2013, 2016). Краудфандингийн үйлчилгээ нь гурван оролцогчоос бүрддэг. Үүнд үйлчилгээ үзүүлэгч буюу краудфандингийн платформ, хөрөнгө оруулагчид болон санхүүжигчид багтана.

Зураг . Бизнесийн хөгжлийн үе шат




Краудфандинг нь ихэвчлэн гарааны бизнес болон ЖДҮ эрхлэгчид буюу бизнесийн хөгжлийн 1 ба 2-р шатанд байгаа компаниудад санхүүгийн эх үүсвэр татах хэрэгсэл болдог (Caroline Kleiner, 2021). Платформууд ил тод байдалд суурилан гарааны бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээг ханган санхүүжилтийг амжилттай хэрэгжүүлж чадвал гарааны бизнес дараагийн бизнесийн хөгжил рүү хурдацтай шилжих боломжтой.

Гэсэн хэдий ч гарааны бизнес нь зах зээлд туршиж үзээгүй шинэ санаанаас бүрддэг учраас платформуудын хувьд гарааны бизнесүүдийн өсөж дэвших боломжтой эсэх, удирдлагын шударга байдал, бодит бус санаа, өөрийгөө баяжуулах менежменттэй эсэхийг бусадтай харьцуулж ялгахад хүндрэлтэй байдаг (Klohn et al. 2018).

Кембрижийн Альтернатив Санхүүгийн Төв (ССАФ) нь 2015 оноос хойш алтернатив санхүүжилтийг судалж, олон нийтийн санхүүжилтийн зах зээлийн талаарх мэдээлэл цуглуулж эхэлсэн. 2019 он хүртэл ССАФ зөвхөн бүс нутгийн зах зээлийн тайланг нийтэлдэг байсан бол 2020 болон 2021 онд дэлхийн хэмжээний жишиг үнэлгээний тайлан нийтэлдэг болсон.

2021 оны тайланд 2020 оны 07 дугаар сараас 2021 оны 05 дугаар сар хүртэл 70 гаруй судалгааны түншүүдээр дамжуулан 170 орчим орны 703 пүүсийн 1660 ажиглалтын утгатай судалгааг 2019 болон 2020 онд хийж Дэлхийн краудфандингийн зах зээлийн хэмжээ, салбарын динамикийг тодорхойлжээ.


Зураг . Дэлхийн краудфандингийн зах зээлийн хэмжээ, 2015–2021.И, ам.доллороор



2015–2018 он хүртэл Хятадын P2P зээлийн салбар нь дэлхийн краудфандингийн зах зээлийн хамгийн том хувийг эзэлж, нэлээд хурдацтай хөгжиж байсан боловч 2018 онд Хятад улсад зохицуулалтын өөрчлөлтүүд хийгдсэнээс хойш дэлхийн зах зээлд эзлэх хэмжээ мэдэгдэхүйц буурсан.

2017 онд Хятад улс краудфандингийн зах зээлийн 86 хувийг, 2019 онд 48 хувийг эзэлж байсан бол 2020 онд краудфандингийн зах зээл жижиг хэсэг болтлоо хумигдаж 1–ээс бага хувийг эзэлж байна. Ийнхүү Хятад улсын зах зээлийн хэмжээ хумигдсанаас хамааран 2018–2019 оны хооронд дэлхийн зах зээлийн хэмжээ 42 хувиар, 2019–2020 онд 35 хувиар буурчээ.

Зураг . Дэлхийн краудфандингийн зах зээлийн хэмжээ, 2018–2021 он, бүсээр



Харин 2018–2021 оны хооронд Амери́к ба Канадын краудфандингийн зах зээлийн хэмжээ 40 хувиар, Их Британийн краудфандингийн зах зээлийн хэмжээ 8 хувиар томорсон бол Хятад улсын хувьд 70 хувиар хумигдсан байна. Харин бусад бүс нутгийн хувьд зах зээлийн хэмжээ харьцангуй тогтвортой өсөлттэй байна

Эх сурвалж: The 2nd Global Alternative Finance Market Benchmarking Report 2021 database


Зураг . Дэлхийн краудфандингийн зах зээлийн хэмжээ, 2021.И, төрлөөр



2021 оны байдлаар дэлхийн краудфандинг 90.0 хувийг зээлд суурилсан, 7.0 хувийг хөрөнгө оруулалтын бус, үлдсэн 3.0 хувийг хөрөнгийн оруулалтад суурилсан краудфандинг тус тус эзэлж байна. Үүнээс харахад зээлд суурилсан краудфандингийн үйлчилгээ нь бусад краудфандингийн хэлбэртэй харьцуулахад хурдацтай хөгжсөн нь ажиглагдаж байна.

Эх сурвалж: The 2nd Global Alternative Finance Market Benchmarking Report 2021 database

Зураг . 2020 оны нэг хүнд ногдох өөр санхүүжилтээр шилдэг 30 улсын жагсаалт



2020–2021 оны нэг хүнд ногдох краудфандингийн санхүүжилтээр АНУ, Их Британи, Сингапур, Латви, Энтони зэрэг улсууд тэргүүлж байна.

Эдгээр улс орнууд 2014 оноос хойш краудфандингийг эрх зүйн орчныг бүрдүүлж, зохицуулалтыг бий болгосон.

Улс орнуудын зохицуулалтад хөрөнгө босгох болон хөрөнгө оруулалтын хязгаарлалт, ил тод байдал, олон нийтийн санхүүжилтийн зар сурталчилгааны хууль, хөрөнгийн шаардлагын бодлого, үйлчлүүлэгчийн хөрөнгийг хамгаалах болон платформд зориулсан тусгай зохицуулалтуудыг нийтлэг тусгаж өгсөн. Зарим улс орнууд олон нийтэд санал болгож буй нийт дүн нь доод босгоос бага тохиолдолд зарим шаардлагуудаас чөлөөлж, Сэндбокс зохицуулалтын орчинд үйл ажиллагаа явуулахыг зөвлөдөг. Жишээлбэл, Саудын Араб, АНУ, Австрали зэрэг улс орнууд олон нийтэд санал болгож буй хэмжээ нь тогтоосон хэмжээнээс бага бол сэндбокс орчинд үйл ажиллагаа явуулахыг санал болгодог. Энэ нь краудфандинг үйлчилгээ нь ихэвчлэн эхний шатанд бүтэлгүйтэх магадлал хамгийн өндөр байдагтай холбоотой байж болзошгүй юм.

Эх сурвалж: The 2nd Global Alternative Finance Market Benchmarking Report 2021